



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Аудитын II баг

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

НИЙТИЙН ЭЗЭМШИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮСЭД ЭКО ОО ХИИХ АЖЛЫГ ТӨСӨВТ ӨРТӨГӨӨС
115.5 САЯ ТӨГРӨГӨӨР ДУТУУ ХЭРЭГЖҮҮЛСЭН, ХӨРӨНГӨ ОРЛОГО АВААГУЙ, ЦЭГ ДЭЭР
БАЙРШУУЛААГУЙ БАЙНА

АУДИТЫН КОД: ХОА-2024-18-20-ШТА-ГА

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 70432545 Цахим хаяг: Erdenetsetsegd@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа

Утас: 7043-2545 Цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Аудитор: Ц.Бадрал

Утас: 7043-2545 Цахим хаяг: badralts@audit.gov.mn

Аудитор: Д.Энхжапран

Утас: 7043-2545 Цахим хаяг: Enkhjergald@audit.gov.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	3
Графикийн товъёог.....	3
Зургийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	5
БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ажлыг зураг төсөлгүй баталж санхүүжүүлсэн, 191.3 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын бус урсгал зардалд зарцуулсан байна.....	6
Зарим төсөл, арга хэмжээний ажлыг зураг төсөлгүй хэрэгжүүлсэн байна.....	6
Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг бүрэн олгоогүй, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй урсгал зардлыг санхүүжүүлсэн байна.	6
Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон эсэхийг тогтоох боломжгүй байна.....	8
БҮЛЭГ 2 Ихэнх хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын гэрээний үүргийн биелэлтийг тооцоогүй, захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна.....	9
Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй гэрээний үүргийн биелэлтийг тооцоогүй байна.	9
Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зохих шатны хяналтыг хэрэгжүүлээгүйгээс зарим төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжээгүй байна.	10
Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.....	10
БҮЛЭГ 3. Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй, зориулалтын дагуу ашиглахгүй байна.....	11
Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглагдахгүй байна.	11
Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй хөрөнгийн гүйцэтгэлийн дараах ашиглалт хангалтгүй байна.....	12
ҮАГ-т хүргүүлэх санал:.....	13
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:.....	13
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:.....	13
Алдаа зөрчлийн нэгтгэлд шалгаагдагч байгууллагаас ирүүлсэн санал, тайлбар:.....	14
Зөрлийн нэгтгэлд ирүүлсэн санал тайлбарт ТАГ-аас хариу хүргүүлсэн тайлбар:...	19
Аудитын тайланг баталсан тушаал:.....	22
Алдаа зөрчлийн нэгтгэл:.....	23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТББ	Тендерийн баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЦТС	Цахилгаан түгээх станц
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Графикийн товчье

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	2023 онд төлөвлөсөн төсөл арга хэмжээ	7
График 2	Шилжих болон шинээр эхлэх төсөл арга хэмжээ	7

Зургийн тайлбар

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Зураг төсөлгүй ЦДАШ-	6
Зураг 2	Зураг төсөлгүй гэрэлтүүлэг	6
Зураг 3	Ажлын даалгаврын дагуу хийгдээгүй ОО	9
Зураг 4	ОО-ын ажлын багцад багтсан кольцо	9

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолд тусгасны дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймагт 2023 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж Аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх, • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх, • Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад Аймгийн засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, сумд, байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч ААН-ийн үйл ажиллагааг хамруулан төлөвлөлт, судалгаа, шинжилгээний баримт, ажлын тайлан, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгч байгууллагуудтай хийсэн гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилт, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагуудын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэв.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуултын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйл цуглуулан, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Тэргүүлэх аудитор Х.Болдбаатар хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн хэрэгжүүлж, Ахлах аудитор Д.Эрдэнэцэцэг, аудитор Ц.Аззаяа, Д.Энхжаргал, Ц.Бадрал нар 2024 оны 04-р сарын 25-наас 06-р сарын 10-нийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:	Аудитын тайланг Төрийн аудитын газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулан, аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, Үндэсний аудитын газарт нэгтгүүлэв.
Хүндрэл бэрхшээл:	Аудитын тайланд хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний судалгаа хийгдээгүй учир газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл, инженер геологийн дүгнэлт зэрэг нь төлөвлөлтийн шаардлага хангаж, хууль батлагдахаас өмнө баталгаажсан эсэхэд дүгнэлт хийх боломжгүй байна. Аудитыг гүйцэтгэх хугацаанд Төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлан баталгаажуулах хугацаа давхцаж, орон нутагт ажиллах хүчний нөөц дутагдалтай байсан нь аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12-р сарын 01-ний өдрийн 10/06 дугаар тогтоолоор ОНТХО-ын 2023 оны төсвийг шилжих хөрөнгө оруулалтад 353.9 сая төгрөг, өмнөх оны дутуу ажлын санхүүжилтэд 60.0 сая, их засварт 1,618.2 сая, нийт 2,032.1 сая төгрөг баталсан байна. Харин 2023 оны 12/02 дугаар тогтоолоор шилжих хөрөнгө оруулалтад 353.9 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтад 4,830.0 их засварт 1,618.2 сая, нийт 6,802.1 сая төгрөг болгож өөрчлөлт оруулж баталсан байна.

Өмнөх онд ОНТХО-аар 22 төсөл арга хэмжээний 2422.5 сая төгрөг батлагдсан, 2023 оны төсөл арга хэмжээний 63 төсөл арга хэмжээнд 6802.1 сая төгрөг батлагдаж өмнөх оны хөрөнгө оруулалтаас 4,379.6 сая төгрөгөөр өссөн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12/02 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд шинээр эхлэх 11 төсөл арга хэмжээний 1190.0 сая төгрөг, өмнөх оноос шилжиж ирсэн 7 төсөл арга хэмжээнд 452.2 сая төгрөг нийт 1642.2 сая төгрөг батлагдсанаас 8 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 1144.8 сая төгрөгийн санхүүжилт, он дамжсан 5 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 247.7 сая төгрөгийн санхүүжилт олгож 5 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар 4 төсөл арга хэмжээг шинээр эхлэхэд 105.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас нэмэлт өөрчлөлт оруулж автомашин авах 8.0 сая төгрөгийн санхүүжилт нэмэгдэж 113.0 сая төгрөг батлагдсан байна. Гүйцэтгэлээр бүрэн хэрэгжсэн 3 төсөл арга хэмжээнд 74.5 сая төгрөгийн санхүүжилт олгож хэрэгжээгүй 2 төсөл арга хэмжээний 38.0 сая төгрөгийн санхүүжилт хэмнэгдсэн байна.

Ховд аймгийн Засаг дарга нь "Алсын хараа-2050" урт хугацааны хөтөлбөр, "Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль", "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг хөгжлийн тулгуур баримт бичгүүдэд үндэслэн "Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", "аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим ажлыг зураг төсөлгүй баталж санхүүжүүлсэн, 191.3 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын бус урсгал зардалд зарцуулсан байна

Зарим төсөл, арга хэмжээний ажлыг зураг төсөлгүй хэрэгжүүлсэн байна.

1.1 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 883.2 сая төгрөгийн өртөгтэй 4 хөтөлбөр, төсөл арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөлгүй ажил баталж хэрэгжүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 160 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 3.2.2.2¹, 3.2.2.3² заалттай нийцээгүй байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцүүлэхээс гадна хүн амын нутагшилт, орон нутгийн хөгжлийн уялдааг хангах зорилтын хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох журмын дагуу боловсруулж эрэмбэлж аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн баримтуудыг ирүүлээгүй тул батлагдсан төсөл арга хэмжээг зураг төсөл, ажлын даалгавар норм дүрмийн дагуу боловсруулсан гэж дүгнэх боломжгүй байна.



Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, шинэчлэхэд шаардагдах хайгуул, геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, байгаль орчны судалгаа, нарийвчилсан зураг, техникийн шаардлага, өртгийн тооцооны нэгдсэн баримт бичгийг бүрэн боловсруулж, магадлалаар баталгаажуулсан байна.

Аудитын илрүүлэлт

- ✓ Жаргалант суманд эрх шилжсэн: Нийтийн эзэмшил, аялал жуулчлалын бүсийн эко ОО хийх. Шим-Ус ОНӨААҮГ-255.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. Зураг төсөлгүй. Онцгой комиссын тогтоол гаргаад шууд гэрээ байгуулсан. Ажлаа бүрэн хийгээгүй байхад хүлээн авах акт дүгнэлт гаргаж санхүүжилтийг бүрэн олгосон,
- ✓ Жаргалант суманд эрх шилжсэн: Төв цэнгэлдэх хүрээлэнгийн ОО хийх: Шим-Ус ОНӨААҮГ-155,0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. Зураг төсөлгүй. Онцгой комиссын шийдвэр гарган шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн
- ✓ Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн дэмжлэг 398.2 сая төгрөгийн өртөгтэй ажлыг Шим-Ус ОНӨААТҮГ шууд гэрээ байгуулан зураг төсөлгүй хэрэгжүүлсэн
- ✓ Цэвэршүүлсэн ундны ус түгээх цэг 75.0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг Баялаг говь ХХК шууд гэрээ байгуулан зураг төсөлгүй гүйцэтгэсэн
- ✓ Буянт сумын Халуун усны барилгын ажлыг Ланз ХХК 91.0 сая төгрөгийн өртөгтэй. Ховд, Буянт сумын халуун ус барих 8.0 сая төгрөгийн гэрээ байгуулж нэгдсэн нэг зургаар хийгдсэн байхад зургийн үнийг төсвөөс 10.0 сая төгрөг шилжүүлж 2.0 сая төгрөгөөр гэрээний үнийн дүнгээс илүү шилжүүлсэн

Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг бүрэн олгоогүй, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй урсгал зардлыг санхүүжүүлсэн байна.

¹ Барилгаа байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

² 3.2.2.3.шаардлагатай тохиолдолд төслийн техник, эдийн засгийн үндэслэл (цаашид "ТЭЗҮ" гэх), техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа (цаашид "ТЭЗҮС" гэх)-г хийлгэсэн байх.

График 1

1.2 Өмнөх оны ИТХ-ын 10/06 тоот тогтоолоор Хөшөөт хөгжил сан татан буугдсанаар сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байсан 11 төсөл арга хэмжээг ОНХО-ын төсвөт шилжих хөрөнгө оруулалтад оруулан баталсан бөгөөд хөрөнгө оруулалтын бус хувийн өмчид шилжих 52.8 сая төгрөгийн 2 ажил, 2023 ИТХ-ын 12/02 тоот тогтоолоор тодотгож баталсан шинээр эхлэх хөрөнгө оруулалтад 4,830.0 сая төгрөг баталснаас хөрөнгө оруулалтын бус урсгалд зардалд 191.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ.



График 2

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12/02 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд шинээр эхлэх 11 төсөл арга хэмжээнд 1190.0 сая төгрөг, өмнөх оноос шилжиж ирсэн 7 төсөл арга хэмжээнд 452.2 сая төгрөг нийт 1642.2 сая төгрөг батлагдсанаас 8 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 1144.8 сая төгрөгийн санхүүжилт, он дамжсан 5 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 247.7 сая төгрөгийн санхүүжилт олгож 5 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжээгүйгээс дутуу санхүүжилт олгосон байна.

2023 онд хэрэгжих их засварын TAX



Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар 4 төсөл арга хэмжээг шинээр эхлэхэд 105.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас нэмэлт өөрчлөлт оруулж автомашин авах 8.0 сая төгрөгийн санхүүжилт нэмэгдэж 113.0 сая төгрөг батлагдсан байна. Гүйцэтгэлээр бүрэн хэрэгжсэн 3 төсөл арга хэмжээнд 74.5 сая төгрөгийн санхүүжилт олгож хэрэгжээгүй 2 төсөл арга хэмжээний 38.0 сая төгрөгийн санхүүжилт хэмнэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24³, 6 дугаар зүйлийн 6.4.1⁴ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2⁵-т заасантай нийцэхгүй байна.

Аудитын илрүүлэлт

- 3 ихэр хүүхдэд зориулсан 2 өрөө байр 26.4 сая, алсын зайн гүйлтийн амжилт тогтоосон Даваажамц 2 өрөө байр (52.25м2) 26.4 сая төгрөг
- Алтай бидний гэр ОУ-н залуучуудын спортын наадам зохион байгуулах, орон нутаг сурталчлах зардал 81.0 сая төгрөг
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуультан, ажилтны сургалт, сурталчилгаа 80.0 сая төгрөг
- Төрийн тахилгат Алтай Хөхийн хайрхны тэнгэрийг тайх ёслолын арга хэмжээ 30.0 сая төгрөг
- Урд онуудад хэрэгжсэн ажлуудын үнийн өсөлтийн зөрүүний дэмжлэгт 149.3 сая, Шинэ Ховд ОНГААТҮГ-ын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд 294.0 сая төгрөг тус тус баталсан,
- Аймгийн ИТХ-ын 2023 оны 12/02 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төсвөөс өмнөх оноос хэрэгжих 4.5 сая төгрөгийн ажил огт хэрэгжээгүй, үерийн далан байгуулах 200.0 сая төгрөгийн ажлыг нэршил өөрчлөн зарцуулсан, өмнөх оны үерийн далангийн хөрөнгө оруулалт хэрэгжээгүй,
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар 4 төсөл арга хэмжээг шинээр эхлэхэд 105.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас нэмэлт өөрчлөлт оруулж автомашин авах 8.0 сая төгрөгийн санхүүжилт нэмэгдэж нийт 113.0 сая төгрөг батлагдсан байна. Гүйцэтгэлээр бүрэн хэрэгжсэн 3 төсөл арга хэмжээнд 74.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон, ороонго ургамлын судалгаа хийх 30.0 сая, автомашин нийлүүлэх 8.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний 38.0 сая төгрөгийн ажил хэрэгжээгүй, төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэн,
- Эрдэнэбүрэн сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын засварын ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа 3 удаа зарлаад компани оролцоогүй гэх боловч ажлын тоо хэмжээг өөрчлөн шууд гэрээ байгуулсан бөгөөд өөрчлөгдсөн тоо хэмжээгээр тендер зарлаагүй, ажлын даалгавар, тоо хэмжээг боловсруулахдаа тооцоо судалгаанд үндэслээгүй.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон эсэхийг тогтоох боломжгүй байна

1.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төслийг холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан эсэхийг мэргэжлийн шинжээч оролцуулаагүй тул нотлох боломжгүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд өмнөх оны аудитаар өгөгдсөн 390.2 сая төгрөгийн албан шаардлага, 1282.7 сая төгрөгийн 3 зөвлөмж өгөгдөж зөрчлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн бодитой ажил байхгүй байгаа нь хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хийгдэж байгаа мэргэжлийн байгууллагын хяналт дүгнэлт хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд хөрөнгө оруулалтын гүйцэтгэл зураг төсөв, норм, стандартын дагуу чанартай хийгдэж байгаа эсэхэд мэргэжлийн шинжээч авч ажиллуулах шаардлагатай байна

³ 4.1.24. "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

⁴ 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁵ 13.3.2. хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

БҮЛЭГ 2 Ихэнх хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын гэрээний үүргийн биелэлтийг тооцоогүй, захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна

Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй гэрээний үүргийн биелэлтийг тооцоогүй байна.

2.1 Аймгийн ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 27-ны 12/02 тоот “2023 оны батлагдсан төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр эхлэх хөрөнгө оруулалтад 26 ажлыг нэмж баталснаар уг ажлууд 2023 оны сүүлийн хагас жилд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсанаас дараах ажлууд төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4⁶-д заасантай нийцэхгүй байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт

- Хотын нийтийн бие засах газар байгуулах /CITY toilet, тамхины цэг/-253.5 сая төгрөг. Эко буянт ХХК-тай гэрээ байгуулсан ч хэрэгжээгүй.
- Ховд хотын гэрэлтүүлэг /Жаргалант сум/-501.2 сая төгрөгийн гэрээтэй. 401.5 сая төгрөгийн санхүүжилт авсан. Бүрэн холбоо констракшн ХХК-хэрэгжүүлсэн. Гэрээний хугацаанд бүрэн хүлээлгэж өгөөгүй
- Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт-213.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжээгүй
- 3*3 сагсан бөмбөг, гар бөмбөг, тоглоомын талбайн цогцолбор /Жаргалант сум/-161.0 сая төгрөгийн өртөгтэй төсөл арга хэмжээ он дамжсан

Төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлээгүй дараах ажлууд байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт

- Буянт голын Жанжин боолтын засвар 35.0 сая төгрөгийн өртөгтэй. 24.5 сая төгрөгийн санхүүжилт авсан. Оргил өнөр ХХК гүйцэтгэсэн. Их засварын ажил бүрэн хийгдээгүй, гэрээний хугацаанд хүлээлгэн өгөөгүй, эхний санхүүжилтээс захиалагчийн хяналтын зардал суутгаагүй,
- Баянбулаг хүүхдийн зуслангийн гадна тохижилт 80.0 сая төгрөгийн гэрээтэй, 72.0 сая төгрөгийн санхүүжилт авсан. Эх нутгийн уулс ХХК гүйцэтгэсэн. Их засварын ажлууд бүрэн хийгдээгүй, гэрээний хугацаанд хүлээлгэн өгөөгүй, эхний санхүүжилтээс захиалагчийн хяналтын зардал суутгаагүй
- "Нийтийн эзэмшил аялал жуулчлалын бүсийн эко ОО 34 ширхэг Шим-Ус ОНӨААТҮГ 255.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр шууд гэрээ байгуулсан ч Талст чиглэл ХХК-аар хийлгэх дамжуулан гэрээ хийсэн."Эко ОО"-г газар дээр нь очиж үзэхэд ажлын даалгаврын дагуу хийж, угсарч хүлээлгэж өгөөгүй Талст чиглэл ХХК-ний хашаанд 27 ширхэг кабин, 12 ширхэг ултай, 15 ширхэг улгүй кольцо, 13 ширхэг тавцангийн хагтан тоологдсоноос 115.5 сая төгрөгийн ажлын даалгавраар өгөгдсөн тоо хэмжээ, төсөвт өртөгт тусгасан материал дутуу хийсэн
- Алтан нутаг гэрээг ХХК-ны авто замын тэмдэг тэмдэглээ 60.0 сая, Ховд Азза ХХК-ны замын ажил 338.9 сая, Мажестик салюшн рөүд ХХК -ны замын тэмдэг тэмдэглээ 154.5 сая, Цэнгийн зам ХХК-ны замын тохижилт, камержуулалт 54.9 сая, Кенелхал ХХК-ны авто зам 30.2 сая, зэрэг ажлууд хугацаандаа бүрэн хэрэгжээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй нийт 638.5 сая төгрөгийн ажил бүрэн хэрэгжээгүй



⁶ төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

- Өмнөх оны үерийн далан байгуулах ажил үр дүнгүй одоог хүртэл хэрэгжээгүй, хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим ажлууд гүйцэтгэлийн дараах хяналт хийгээгүйгээс хөрөнгийн үр дүн буурсан

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зохих шатны хяналтыг хэрэгжүүлээгүйгээс зарим төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжээгүй байна.

2.2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын даргын А/33 тоот захирамжаар "Аймгийн хэмжээнд 2022-2023 оны улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын чанар, үр дүнд хөндлөнгийн хяналт шинжилгээ хийх" ажлын хэсэг байгуулагдсан.

Хяналт шалгалтын ажлын хэсэг нийт бүрэлдэхүүний хамт 13 суманд ажиллаж 7 удаа хуралдсан байна. ОНТХО-ын 10 ажил шалгагдсан ба хяналт шалгалтын бүрэлдэхүүнээс аймгийн Засаг дарга, ХОХБТХ-т 6 дүгнэлт бүхий 8 зөвлөмжтэй ажлын тайлан хүргүүлсэн ч зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажил хангалтгүй байна.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага ОНТХО-ын 2 ажилд хяналт хэрэгжүүлж бусад хөрөнгө оруулалтын ажилд хяналт хэрэгжүүлээгүйгээс дараах зөрчил илэрч байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

- Музейн барилгын дээврийн засварын ажил Нурбах ХХК 29.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн нь гадна фасад ягаанаар будсан нь өнгөө алдсан,
- Прогресс сургуулийн спорт заалны барилгын засварын ажил Тажийн үр сад ХХК 108.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн нь шалны лак хуурсан, хананы будаг хуурсан зэрэг хөрөнгө оруулалтын ажлыг чанаргүй хийж гүйцэтгэсэн,
- "Нийтийн эзэмшил аялал жуулчлалын бүсийн эко ОО 34 ширхэг" Шим-Ус ОНӨҮГ-ын 255.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн ажлын захиалагч болох Жаргалант сумын ЗДТГ-аас гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавиагүйгээс ажлын даалгаврын дагуу хийгээгүй, сумын Засаг даргын 2023.10.24-ний А/479 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2023.11.02-ны өдөр ажлыг хүлээн авсан ч одоог хүртэл бүрэн хийж дуусгаагүй ашиглалтад ороогүй,
- ОНТХО-аар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтын зардал 83.5 сая төгрөгийг суутгасан боловч хяналт хэрэгжүүлж ажилласан гүйцэтгэлийн тайлан ирүүлээгүй, хяналтын зардлыг хяналт хийх зохих байгууллага руу шилжүүлээгүй хяналт хэрэгжүүлсэн баримт байхгүй,
- БХС-аар хэрэгжүүлсэн ундны усны дүгнэлтэд хяналт шалгалт хийсэн тайлан, дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын үр дүн байхгүй, бусад хэрэгжүүлсэн ажлын үр дүн гарсан талаар засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт биелэлтийг тооцоогүй,

Хэрэгжүүлж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

2.3 Ашиглалтад хүлээн авсан хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгасан ч хүлээн авсан акт шийдвэр нь гарч ашиглагдаж байгаа зарим хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөрөнгийн ИТХ-ын хөрөнгө орлого авах тогтоол шийдвэр гарсан байхад орлого авч бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт

- "ЦДАШ /Жаргалант сум, Цамбагараа баг/" Жаргалант сумын ИТХ-ын даргын 2023.12.27-ны 66 дугаар захирамжаар Ховд ЦТС ХХК-ний 150.0 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэх тухай захирамж гарсан боловч бүртгэж аваагүй,

- "Нийтийн эзэмшил аялал жуулчлалын бүсийн эко ОО 34 ширхэг" 255.0 сая төгрөгийн ажлыг Жаргалант сумын Засаг даргын 2023.10.24-ний А/479 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2023.11.02-ны өдөр ажлыг хүлээн авсан акт үйлдсэн боловч хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй,
- "Сумдын нэгдсэн цэвэр усны шугам сүлжээний ажлын дэмжлэг 355.0 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгийг /Дуут, Чандмань, Дарви сум/" хүлээж авсан боловч данс бүртгэлд тусгаагүй
- Замын сангаар хэрэгжүүлсэн Манхан сум, Жаргалант сумын шинэ суурьшлын бүсийн замын зураг төсөл хийсэн Ихэр мөнх ХХК-ны 2 ажлын 359.9 сая, Ховд-Дөргөн сумын замын зураг төсөө Гео урбан консалтинг ХХК-ны хэрэгжүүлсэн 49.9 сая төгрөгийн зураг төсөө урьдчилж гарсан зардалд эсвэл дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгээгүй, Мөнх цэлмэг ноёд ХХК-ны хэрэгжүүлсэн зам, замын нөхөөс 159.7 сая төгрөг, Гэрэлтэх бүтээмжтэй баяр ХХК 19.9 сая, Босоо оргил ХХК-ны 19.9 сая төгрөгийн замын тэмдэг тэмдэглэгээ, Алтан орд констракшн ХХК-ны хэрэгжүүлсэн Амарсанаагийн нэрэмжит цэцэрлэгийн гэрэлтүүлгийн тохижилтын ажлын 153.9 сая төгрөгийн хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2⁷-д гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул ашиглалтад хүлээн авсан хөрөнгүүдийг баримт бичгийг бүрдүүлэн данс бүртгэлд тусгаж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй, зориулалтын дагуу ашиглахгүй байна

Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглагдахгүй байна.

3.1 Тайлант оны зарим төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй, өмнөх оны хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн дараах ашиглалт хангалтгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Өмнөх оны Алтан бэрс интернешнл ХХК-ны 161.8 сая төгрөгөөр гэрээ байгуулж 138.3 сая төгрөгийн санхүүжилт авч хэрэгжүүлсэн Мөст сумын эрүүл мэндийн төв, моргийн барилгын их засварын ажлыг одоог хүртэл бүрэн хэрэгжүүлж хүлээлгэж өгөөгүй, зориулалтын дагуу бүрэн ашиглаж чадахгүй байгаа
- Өмнөх онд хэрэгжүүлсэн Ховд хотын үерийн хамгаалалтын далангийн шинэчлэл, засварын ажил /Жаргалант сум/ өнөөдрийг хүртэл зориулалтын дагуу ашиглагдаагүй,
- Өмнөх онд Уран минж ХХК-ны хэрэгжүүлсэн Дөргөн сумын бярааз засах 39.0 сая, дотуур байрны их засвар 161.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн ч иргэдийн сэтгэлд нийцсэн чанартай хэрэгжүүлээгүй санал гомдол тасрахгүй байгаа,
- Он дамжуулан хэрэгжүүлсэн Голденкристал ХХК-ны хэрэгжүүлсэн 29.9 сая төгрөгийн өртөгтэй Буянт сумын камержуулалт хийх ажил шаардлага хангахгүй ашиглалт муу,
- Өмнөх онд Засаг даргын А/604 тоот захирамжаар олгосон Талст чиглэл ХХК-д 100.0 сая, Хоногт хас ХХК-д 80.0 сая төгрөгийн хог хаягдлыг боловсруулах бага оврын үйлдвэр байгуулах төслийн зээл олгосон боловч гэрээний үр дүнг тооцож гэрээ дүгнээгүй, зээлийн хуваарийн дагуу Талст чиглэл ХХК 1.2 сая төгрөгийн хүү төлөөгүй

⁷ "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал бүртгэнэ, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.4-д "Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлээлэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана."

Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй хөрөнгийн гүйцэтгэлийн дараах ашиглалт хангалтгүй байна.

3.2 Тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан хөрөнгө оруулалт хийгдэж байгаа дараах ажлууд үр дүнтэй хэрэгжсэн байна. Тухайлбал:

- ✓ Ланз ХХК-ны хэрэгжүүлсэн Ховд, Буянт суманд хийж гүйцэтгэсэн халуун усны барилга
- ✓ Төгс шимт ХХК-ны хэрэгжүүлсэн Мөст сумын Соёлын төвийн тоног төхөөрөмж
- ✓ Баялаг говь ХХК-ны Жаргалант суманд хэрэгжүүлсэн халуун хүйтэн устай ухаалаг худаг
- ✓ Оргил өнөр ХХК-ны хэрэгжүүлсэн Зэрэг сумын цэцэрлэгийн барилгын их засвар
- ✓ Төгс шимт оргил ХХК-ны хэрэгжүүлсэн Политехник коллежийн урлагийн заалны тохижилт
- ✓ Ховдын өргөө ХХК-ны хэрэгжүүлсэн магистрал шугам татсаны үр дүнд орон нутгийн төсвийн дэмжлэгээр иргэдийн хувь оролцоотой цэвэр бохир шугамд 87 өрх холбогдсон

Үр дүнтэй хэрэгжсэн хөрөнгө оруулалт байгаа ч үр дүнгүй хэрэгжсэн хөрөнгө оруулалт дийлэнх байна. Шалтгаан нь: Хөрөнгө оруулалтыг бодит гүйцэтгэлээр үлдэгдэл санхүүжилтийг олгодоггүй, гүйцэтгэлийн дараах ашиглалтын зардал төсөвт тусдаагүй, барилга барьж байгаа аж ахуйн нэгжүүд дулаан, цэвэр бохир усны шугам татахдаа засмал зам болон явган хүний замыг сэтэлж буцаан засдаггүй, хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр дүнг тооцож хяналт хэрэгжүүлэн ажиллаагүйгээс эдийн засгийн үр өгөөж буурч хөгжлийн бодлого төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хөрөнгө оруулалтын хуулийн хэрэгжилт хангалтгүй байх алдаа зөрчил давтагдсаар байна.

Аудитын илрүүлэлт

- Нийт сумдын ундны ус түгээж буй худагт усны шинжилгээ хийсэн зарцуулалтын тайлан баримт байхгүй, гаргасан дүгнэлт нь 2022 оны дүгнэлттэй, хийсэн ажлыг хяналт хэрэгжүүлэн хүлээн авсан акт байхгүй, сум бүрд дүгнэлтийн зөвлөмж хүргүүлээгүй, дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн бодитой ажил байхгүй үр дүн гараагүй
- Ховд хотын авто замын шинэчлэлт /Жаргалант сум, Домботын уулзвараас Номингийн уулзвар хүртэлх/ АЗЗА ХХК-ны 271.9 сая төгрөгөөр гүйцэтгэсэн авто замын засвар үр дүнтэй хэрэгжээгүй,
- Замын сангаар Мөнгөн ноёд цэлмэг ХХК-ны 102.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн Жаргалант сумын авто замын шинэчлэл, замын тэмдэг, тэмдэглээ хийх ажил зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжээр хийлгэсэн, Засгийн газрын 124 дүгээр тогтоолын дагуу худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан
- Жаргалант сумын сларри сийл технологиор хийсэн гадаргуутай хатуу хучилттай авто замын хашлага будах Гэрэлтэх бүтээмжтэй баяр ХХК-ны 19.9 сая, Босоо оргил ХХК-ны 19.7 сая төгрөгийн ажлууд үр дүнтэй хэрэгжээгүй төсөв үргүй зарцуулагдсан
- Өмнөх оны хогны менежментийг сайжруулах төслийн дэмжлэг /хөтөлбөр/-өөс Хог хаягдлыг төлбөртэй хүлээн авах автомат "ЭКОКЭШ" төхөөрөмж 2 ширхэг нийлүүлэх ажлыг ТЕХНОЛОГИБРИДЖ ХХК-тай 12.5 сая төгрөгөөр 2022.07.30-нд хүлээн авахаар гэрээ байгуулж 6.2 сая төгрөг олгосон боловч одоог хүртэл нийлүүлэгдээгүй,
- Өмнөх онд аймгийн өөсний нөөц бүрдүүлэлт хийх 219.0 сая төгрөгийн өөсний зарцуулалт болон үлдэгдлийн тооцоо хийж үр дүнг гаргаагүй
- Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 20 сая мод хөтөлбөрөөс хэрэгжсэн хөтөлбөрөөс аймгийн хэмжээнд хэчнээн хэмжээний мод хүлээн авч модны амьдралын хувь тооцсон дүгнэлт, хөтөлбөрийн эдийн засгийн үр өгөөжийг тооцсон баримт материал байхгүй

- Өмнөх онд сумдын халаалтын зардалд шүүхийн шийдвэрээр 1495.1 сая төгрөг нөхөн олгосон боловч өнөөдрийг хүртэл аж ахуй нэгжтэй гэрээгээ шинэчлээгүй, халааж байгаа талбайн мкв-д хэмжилт хийж хяналт хэрэгжүүлээгүй, гэрээний үр дүнг тооцож дүгнээгүй

ҮАГ-т хүргүүлэх санал:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа ажилд үндэслэлгүй зураг, төсөв зохиож санхүүжилт батлуулж байгаа, хэрэгжээгүй хөрөнгө оруулалтыг хүлээн авсан актаар баталгаажуулан санхүүжилт авч байгааг анхаарч зураг төсөв хийх тусгай зөвшөөрөл олгож байгаа байгууллага, хэрэгжээгүй ажилд эрх нээж санхүүжилт олгож байгаа албан тушаалтныг хариуцлага тооцож хууль хяналтын байгууллагад шилжүүлэх санал оруулж байна.

Аудитаар нийт 4109422.6 мянган төгрөгийн 13 зөрчил илэрснээс 129796.1 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт, 3724060.2 мянган төгрөгийн 4 албан шаардлага 255566.3 мянган төгрөгийн 4 зөвлөмж бичигдлээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажил иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцэж амьдралын шинж чанар дээшилсэн ч зарим хөрөнгө оруулалтыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгж гэрээний үүргээ биелүүлээгүй, захиалагч тал гэрээний үр дүнг тооцож ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэв-Ганди-д

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлсэн тайлан, зөвлөмжийн биелэлтийг хангуулж хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх

Аймгийн Засаг дарга Э.Болормаа –д

2. Тайлант он болон өмнөх онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл үр дүнд хяналт хэрэгжүүлж гүйцэтгэгч байгууллагын гэрээний үүргийн биелэлтийг тооцож дотоод хяналтыг хэрэгжүүлэх, чиг үүргийн байгууллагуудын шат шатны ажилтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэх

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэбат-т

3. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгох, хэрэгжээгүй хөрөнгө оруулалтыг гүйцэтгэл дутуу байхад хүлээн авсан актаар баталгаажуулж санхүүжүүлэхгүй байх
4. Төлөвлөсөн ажлыг хуулийн хугацаанд худалдан авах ажиллагаа зохион байгуулахад хяналт хэрэгжүүлэх, босго үнээс давсан ажилд шууд гэрээ байгуулсан ажлыг санхүүжүүлэх эрх нээхгүй байх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

- Өмнөх онд сумдын халаалтын зардалд шүүхийн шийдвэрээр 1495.1 сая төгрөг нөхөн олгосон боловч өнөөдрийг хүртэл аж ахуй нэгжтэй гэрээгээ шинэчлээгүй, халааж байгаа талбайн мкв-д хэмжилт хийж хяналт хэрэгжүүлээгүй, гэрээний үр дүнг тооцож дүгнээгүй

ҮАГ-т хүргүүлэх санал:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа ажилд үндэслэлгүй зураг, төсөв зохиож санхүүжилт батлуулж байгаа, хэрэгжээгүй хөрөнгө оруулалтыг хүлээн авсан актаар баталгаажуулан санхүүжилт авч байгааг анхаарч зураг төсөв хийх тусгай зөвшөөрөл олгож байгаа байгууллага, хэрэгжээгүй ажилд эрх нээж санхүүжилт олгож байгаа албан тушаалтныг хариуцлага тооцож хууль хяналтын байгууллагад шилжүүлэх санал оруулж байна.

Аудитаар нийт 4109422.6 мянган төгрөгийн 14 зөрчил илэрснээс 129796.1 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт, 3724060.2 мянган төгрөгийн 6 албан шаардлага 255566.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж бичигдлээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажил иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцэж амьдралын шинж чанар дээшилсэн ч зарим хөрөнгө оруулалтыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгж гэрээний үүргээ биелүүлээгүй, захиалагч тал гэрээний үр дүнг тооцож ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг дарга Э.Болормаа –д

1. Тайлант он болон өмнөх онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл үр дүнд хяналт хэрэгжүүлж гүйцэтгэгч байгууллагын гэрээний үүргийн биелэлтийг тооцож дотоод хяналтыг хэрэгжүүлэх, чиг үүргийн байгууллагуудын шат шатны ажилтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэх

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэбат-т

2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгох, хэрэгжээгүй хөрөнгө оруулалтыг гүйцэтгэл дутуу байхад хүлээн авсан актаар баталгаажуулж санхүүжүүлэхгүй байх
3. Төлөвлөсөн ажлыг хуулийн хугацаанд худалдан авах ажиллагаа зохион байгуулахад хяналт хэрэгжүүлэх, босго үнээс давсан ажилд шууд гэрээ байгуулсан ажлыг санхүүжүүлэх эрх нээхгүй байх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР